

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

Байгууллагын нэр:

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК

Нэгжийн нэр:

Дамжуулах сүлжээ ашиглалтын газар,  
Дамжуулах сүлжээний хэлтэс, Өгөгдлийн  
сүлжээний төв

Албан тушаалын нэр:

Инженер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Инженер

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөдөө орон нутгийн Интернет болон VPN сүлжээний үйл ажиллагааны тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, өдөр тутам хяналт тавьж ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Хөдөө орон нутгийн интернет болон өгөгдлийн суурь сүлжээний найдвартай тасралтгүй ажиллагааг хангах, сүлжээний технологийн удирдлагыг оновчтой зохион байгуулахад шаардлагатай дүрэм, журам, стандартыг мөрдөж сүлжээнд гарсан гэмтэл, саатлын шинж чанар, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, таслан зогсооход чиглэсэн оновчтой шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэх;
2. Интернет протоколд суурилсан шинэ техник, технологи, хэрэглээний судалгааг хийх, шийдэл гаргах, хэрэгжүүлэх;
3. Өгөгдлийн сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, өгөгдлийн сүлжээнд өргөтгөл сайжруулалт хийх, шинээр төлөвлөх, орон нутагт томилолтоор ажиллах;
4. Шаардлага гарсан үед төхөөрөмжийн зогсвор, замчлагч төхөөрөмж, холбогч төхөөрөмж, шилэн кабель болон UTP кабель татах, угсралт суурилуулалтын ажлыг хийх;
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөн ажиллах;
6. Удирдлагыг мэдээлэлээр хангах, ажлаа тайлагнах, танилцуулах, өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>1. Улаанбаатар болон орон нутгийн сүлжээнд ажиллаж байгаа сүлжээний тоног төхөөрөмжүүдийн ажиллагааны байдалд тогтмол хяналт тавих; хуваарьт үзлэг үйлчилгээг хийх, төхөөрөмжийн ажиллагааны байдлын талаар үнэлэлт дүгнэлт хийх, танилцуулах;</li> <li>2. Ээлжийн болон бусад инженерүүдтэй нягт хамтран ажиллах, шаардлагатай тохиргоо болон төхөөрөмжийн ажиллагааны талаар зөвлөгөө зааварчилга авах, хийж гүйцэтгэх хяналт тавих.</li> </ol>
2 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>1. Интернет сүлжээний төхөөрөмжийн өрөө, зай тэжээл дизель генераторын өрөөнд урьдчилан сэргийлэх графикт үзлэг үйлчилгээ, хэмжилт тохиргоог хариуцсан инженер техникийн ажилтантай хамтран хуваарийн дагуу хийх, өрөөний эмх цэгцтэй байдал кабелийн тэмдэглэгээ, технологийн дагуу холболтыг хийх;</li> <li>2. Шинээр харилцан холболт хийж байгаа гадны байгууллагуудын инженерүүдтэй хамтарч урсгалын холболтыг өөрийн төхөөрөмж дээрээ технологийн дагуу хийх;</li> <li>3. Интернет болон VPN хэрэглэгчийн урсгалын хурд гэрээт хурдандаа хүрч байгааг тогтмол шалгаж байх, шаардлагатай тохиргоог хийх;</li> <li>4. Шинэ төхөөрөмж сүлжээнд холбогдсон үед техникийн өгөгдөл болон хэрэглэгчийн мэдээллийг тасгийн нэгдсэн бүртгэл тогтмол бүртгэж, бүртгэлийг тогтмол шинэчлэл хийх. Урсгалын акт болон ажлын хүснэгт, төлөвлөгөө тайлан, диаграм, график шийдлүүдийг баримтжуулж баталгаажуулах;</li> <li>5. Нэгдсэн бүртгэлээс шаардлагатай судалгаануудыг цаг тухайд гаргаж байх.</li> </ol>
3 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн өгөгдлийн сүлжээнд ажиллаж байгаа сүлжээний тоног төхөөрөмжүүдийн ажиллагааны байдалд хяналт тавьж ажиллах, шаардлагатай тохиргоо хийх, төхөөрөмжүүдийг хяналтын систем рүү оруулах, төхөөрөмжийн ажиллагааны байдлын талаар үнэлэлт дүгнэлт хийх, танилцуулах;</li> <li>2. Тоног төхөөрөмжүүдийн Firmware, IOS программ хангамжийн шинэчлэлтийг тогтмол хийх;</li> <li>3. Орон нутгийн IT инженерүүдтэй нягт хамтран ажиллах, шаардлагатай тохиргоо болон төхөөрөмжийн ажиллагааны талаар зөвлөгөө зааварчилга өгөх, хийж гүйцэтгүүлэх, хяналт тавих;</li> <li>4. Тоног төхөөрөмжийн хуваарьт үзлэг үйлчилгээний хуваарь боловсруулах, хэрэгжүүлэх.</li> </ol>
4 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн интернет болон VPN хэрэглэгчдийн техникийн нөхцөл боловсруулах, холболтын шийдэл гаргах, аймгийн газруудын ерөнхий инженерүүдтэй холбогдон гүйцэтгүүлэх;</li> <li>2. Орон нутгийн төхөөрөмжүүдийн тохиргоог backup хийх, гэмтэл гарсан үед богино хугацаанд сэргээх;</li> <li>3. Орон нутагт ажиллахдаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг сахиж ажиллах;</li> <li>4. Шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн талаар орон нутгийн инженер техникийн ажилтуудад зааварчилга өгөх, сургалт хийх, технологийн карт боловсруулж танилцуулах;</li> <li>5. Орон нутгийн сүлжээ хариуцсан инженер техникийн ажилтнуудтай хамтран ажиллах, удирдан чиглүүлэх, ашиглаж байгаа технологийн талаар мэдлэг өгөх;</li> <li>6. Мэдээлэл технологи болон IP сүлжээнд шинээр нэвтэрч буй орчин үеийн технологиудыг судлаж, үйлчилгээний шийдэл боловсруулах, танилцуулах, нэвтрүүлэх;</li> <li>7. Ашиглалт үйлчилгээг дэмжих, сайжруулах зорилго бүхий шийдэл гаргах, техникийн шаардлагуудыг боловсруулах, ашиглалтад оруулах;</li> <li>8. Ажлын бус цагаар сүлжээнд гэмтэл саатал гарсан үед хэлтсийн дарга болон ахлах инженерт заавал мэдэгдэж байх;</li> </ol>

	<p>9. Ажлын төлөвлөгөө, тайланг 1 сар тутамд тогтмол өгөх.</p>
5 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>1. Компанийн дотоод журам хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн дүрэм, улсын хяналтын дүрэм, харилцаа холбооны хууль, түүнд заагдсан технологийн дүрмийг баримталж ажиллах;</li> <li>2. Гэмтэл сааталд явахдаа ХАБЭА-н зааварчилгааг ажлын цагаар ахлах инженерээс, ажлын бус цагаар тухайн үед ээлжинд ажиллаж байгаа диспетчерээс авна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу тогтмол хэрэглэж осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх;</li> <li>3. Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар ХАБЭА-н ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах /27.5.3/</li> <li>4. Ажлын байран дахь үйл ажиллагааны явцад хүний амь нас эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;</li> <li>5. MNS 5596:2020 стандарт бүхий Мэдээлэл холбооны сүлжээний байгууламжид ажиллагсад тавих аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөж ажиллах;</li> <li>6. Ажлын байран дахь эргономикийн эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэн, үнэлж, арилгах арга хэмжээг авах, ХАБЭА-н ажилтантай хамтарч ажиллах;</li> <li>7. Өөрийн хариуцсан ажлын хүрээнд компанийн ХАБЭА-н дүрэм, Галын аюулын байдлын дүрмийн хэрэгжилтийг хангуулах, ХАБЭА-н гурван шатны хяналтыг хийх (I шат).</li> </ol>
6 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>1. Удирдлагыг газрын чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;</li> <li>2. Удирдлагад ажлаа тайлагнах, танилцуулах;</li> <li>3. Компанийн бизнесийн болон сүлжээний нууцлалыг хамгаалах;</li> <li>4. Шаардлагатай үед ажлын байран дээр дуудагдаж ажиллана. Зайлшгүй тохиолдолд ажлын байранд сэлгэн ажиллах ба тухайн ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг гүйцэтгэнэ.</li> </ol>
<p><b>III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</b></p>	
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, инженер /061/.
Мэргэшил	Мэргэшлийн сургалтад хамрагдсан бол давуу тал болно.
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	Англи хэлний зохих мэдлэгтэй, дээд түвшний программын хэл, өгөгдлийн холбооны систем; бүх үйлдвэрлэгчийн Router, Switch, Firewall дээр тохиргоо хийх, VoIP, TCP/IP протокол, (Windows, Linux, Unix) үйлдлийн систем, өгөгдлийн бааз, интернэт сүлжээний ажиллагааны зарчмын мэдлэгтэй, инженерийн түвшинд өгөгдлийн холбооны системийн үйл ажиллагааг бие даан удирдах, ашиглалтанд гарсан асуудлыг бие даан шийдэл шийдвэр гаргах, үнэнч, шударга, удирдан зохион байгуулах, багаар ажиллах, асуудалд дүн шинжилгээ хийх чадвартай, зөв хандлагатай байх.

**IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Орон нутаг хариуцсан ахлах инженер

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

1. Компанийн нийт ажилтнууд
2. Холбогдох бусад байгууллага, иргэн хуулийн этгээд

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

**БОЛОВСРУУЛСАН:**

**БАТАЛСАН:**

ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА



А.ДАМДИН

2023 оны 03-р сарын 17-ны өдөр

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

УЛААНБААТАР ХОТ

МЭДЭЭЛЭЛ  
ХОЛБООНЫ

(тамга/тэмдэг)



Д.МЯНГАНБААТАР

2023 оны 03-р сарын 17-ны өдөр